

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2024/04/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Туяа Утас: 99799709 Цахим хаяг: tuyan@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг бар
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2024.05.25 № 409
танил _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ЭНХТӨР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Дархан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгө 436,537.3 мянган төгрөг, авлага 150,136.0 мянган төгрөг, урьдчилж гарсан зардал 47,045.5 мянган төгрөг, бараа материал 193,397.9 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,510,731.7 мянган төгрөгийн тус тус үлдэгдэлтэй, нийт хөрөнгө 4,337,848.4 мянган төгрөг байна.

Тайлант онд аймгийн төсвөөс 439,700.7 мянган төгрөгийн дэмжлэг авч, 585,912.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, төсвийн байгууллагуудад 1,201,433.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос ерөнхий орлогын дансанд 134,565.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Нэмэлт санхүүжилтийн дансанд 138,027.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, зарцуулжээ.

20240515

Аудитын гол асуудал

Дархан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитад ирүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх, төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлэх, Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдлийг барагдуулах, төсвийн нягтлан бодогч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх, санхүүгийн тайлан гаргалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн байгууллагууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, тайланг гаргах зэрэг асуудлуудыг анхаарах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,056,988.3	827,116.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	524,905.5	436,537.3
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	4а, 4б	0.0	0.0
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	179,219.9	150,136.0
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	238,976.6	47,045.5
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	113,886.4	193,397.9
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	0.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		3,194,076.0	3,510,731.6
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	11а, 11б	0.0	0.0
37100	Урт хугацаат хадгаламж		0.0	0.0
37200	Үнэт цаас		0.0	0.0
37300	Урт хугацаат зээл		0.0	0.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,194,076.0	3,510,731.6
39100	Газар		0.0	1,714.0
39200	Биет хөрөнгө		3,165,371.0	3,481,409.6
39300	Биет бус хөрөнгө	13	28,705.0	27,608.0
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	14	0.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		4,251,064.3	4,337,848.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,197,842.3	1,090,584.8
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	1,197,842.3	1,090,584.8
41100	Богино хугацаат үнэт цаас		0.0	0.0
41200	Богино хугацаат зээлийн өглөг	16а, 16б	0.0	0.0
41300	Өглөг	17а, 17б	2,320.0	1,501.0
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	1,195,522.4	1,089,083.7
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		0.0	0.0
42100	Урт хугацаат үнэт цаас	19	0.0	0.0
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	0.0	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		3,053,222.0	3,247,263.7
51	Засгийн газрын хувь оролцоо		3,053,222.0	3,247,263.7
51100	Засгийн газрын оруулсан капитал		457,233.7	457,233.7
51200	Хуримтлагдсан үр дүн		2,541,494.4	2,733,822.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		54,493.8	54,493.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		4,251,064.3	4,337,848.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,246,710.40	3,645,800.50
11	ТАТВАРЫН ОРЛОГО		490,427.60	567,524.20
110	Орлогын албан татвар		217,963.10	261,125.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		217,963.10	261,125.60
113	Хөрөнгийн албан татвар		100,589.70	95,055.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж		171,874.80	211,343.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,143,100.00	926,484.10
120	Нийтлэг татварын бус орлого		1,143,100.00	926,484.10

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,613,182.80	2,151,792.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	2,348,459.20	2,913,496.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,348,459.20	2,913,496.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,184,356.90	1,570,896.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		277,180.50	432,856.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		34,715.40	53,524.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		230,791.20	65,262.70
2104	Хангамж, бараа материалын зардал		26,727.60	38,902.10
2105	Нормативт зардал		551.6	582.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		21,871.20	30,794.50
2107	Томилот, зочны зардал		12,537.00	21,842.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		312,769.50	640,089.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		267,212.90	287,042.50
211	ХҮҮ		0	0
212	ТАТААС		0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,164,102.30	1,342,600.60
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		898,251.20	732,303.60
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		0	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,241,770.80	539,976.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-1,343,519.50	192,327.70

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		2,672,740.60	3,093,797.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО		490,427.60	567,524.20
110	Орлогын албан татвар		217,963.10	261,125.60
1100	Хувь хүний орлогын албан татвар		217,963.10	261,125.60
113	Хөрөнгийн албан татвар		100,589.70	95,055.50
118	Бусад татвар, төлбөр, хураамж		171,874.80	211,343.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		26,056.60	31,190.90
1181	Газрын төлбөр		145,598.20	178,486.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		220	1,665.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		569,130.20	374,018.00
120	Нийтлэг татварын бус орлого		569,130.20	374,018.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,613,182.80	2,152,255.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,288,782.90	2,779,777.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,288,782.90	2,779,777.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,059,194.40	1,437,176.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		371,966.30	522,468.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		60,273.50	80,239.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		229,191.30	65,342.70
2104	Хангамж, бараа материалын зардал		163,101.20	130,469.30
2105	Нормативт зардал		551.6	582.6

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		15,193.20	41,738.80
2107	Томилолт, зочны зардал		12,537.00	21,842.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		117,368.70	340,016.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		89,011.60	234,477.00
211	ХҮҮ		0	0
212	ТАТААС		0	0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,229,588.60	1,342,600.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		383,957.70	314,020.30
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		598,288.50	402,388.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		598,288.50	402,388.40
2200	Дотоод эх үүсвэрээр		598,288.50	402,388.40
2260	Гадаад эх үүсвэрээр		0	0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-598,288.50	-402,388.40
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-90,000.00	0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		90,000.00	0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-304,330.80	-88,368.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		829,236.30	524,905.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		524,905.50	436,537.30

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,840,095.8	0.0	5,840,095.8
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-141,791.7	0.0	-141,791.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,698,304.1	0.0	5,698,304.1
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	-1,301,562.6	0.0	-1,301,562.6
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	-1,343,519.5	0.0	-1,343,519.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,053,222.0	0.0	3,053,222.0
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,053,222.0	0.0	3,053,222.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0

13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,053,222.0	0.0	3,053,222.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	1,714.0	0.0	1,714.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	192,327.7	0.0	192,327.7
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,247,263.7	0.0	3,247,263.7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,807,981.6	1,386,910.1	421,071.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,145,681.0	1,010,365.2	135,315.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,138,601.0	1,003,986.4	134,614.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	478,934.5	432,813.2	46,121.3
210101	Үндсэн цалин	309,336.0	284,580.2	24,755.8
210102	Нэмэгдэл	122,946.4	103,353.0	19,593.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,018.5	6,827.0	8,191.5
210104	Урамшуулал	11,514.4	19,399.1	-7,884.7
210105	Гэрээт ажлын хөлс	20,119.2	18,653.9	1,465.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,913.8	53,567.6	6,346.2
210201	Тэтгэврийн даатгал	40,741.5	36,716.9	4,024.6
210202	Тэтгэмжийн даатгал	4,793.0	4,324.7	468.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,834.4	3,459.7	374.7
210204	Ажилгүйдлийн даатгал	958.6	822.3	136.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,586.3	8,243.9	1,342.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	271,369.0	269,435.8	1,933.2
210301	Гэрэл, цахилгаан	30,800.0	29,254.9	1,545.1
210302	Түлш, халаалт	236,773.0	236,772.9	0.1
210303	Цэвэр, бохир ус	3,796.0	3,408.0	388.0
2104	Хангамж, бараа материалын зардал	36,844.5	34,597.3	2,247.2
210401	Бичиг хэрэг	3,101.1	2,483.3	617.8
210402	Тээвэр, шатахуун	25,666.6	25,603.1	63.5
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,918.1	4,474.0	1,444.2
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,158.7	2,036.9	121.8
2105	Нормативт зардал	1,588.6	582.6	1,006.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,588.6	582.6	1,006.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,311.9	49,281.2	3,030.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,360.4	715.9	644.5
210602	Тавилга	15,000.0	14,698.4	301.6
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1.5	0.0	1.5
210604	Урсгал засвар	35,950.0	33,866.9	2,083.1
2107	Томиллолт, зочны зардал	22,975.2	21,842.0	1,133.2
210702	Дотоод албан томиллолт	22,975.2	21,842.0	1,133.2

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	148,926.7	88,975.1	59,951.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	144,657.8	86,819.7	57,838.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,058.8	0.0	1,058.8
210803	Даатгалын үйлчилгээ	932.4	932.4	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	397.8	397.0	0.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	171.7	99.0	72.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	719.4	597.0	122.4
210807	Газрын төлбөр	988.8	130.0	858.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,736.8	52,891.6	12,845.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,100.0	48,378.0	4,722.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,636.8	4,513.6	8,123.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,080.0	6,378.8	701.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,080.0	6,378.8	701.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,080.0	6,378.8	701.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	433,526.8	376,544.9	56,981.9
223001	Бусад хөрөнгө	433,526.8	376,544.9	56,981.9
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	228,773.8	0.0	228,773.8
230001	Эргэж төлөгдөх зээл	228,773.8	0.0	228,773.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,807,981.6	1,341,095.5	466,886.1
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,443,679.9	1,305,396.8	138,283.1
320001	Орон нутгийн төсвөөс	1,205,151.5	1,066,868.4	138,283.1
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	238,528.4	238,528.4	0.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	364,301.7	35,698.7	328,603.0
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,715.0	27,520.9	46,194.1
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,400.0	8,177.8	-6,777.8
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	289,186.7	0.0	289,186.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	308,599.1	-308,599.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	262,784.5	-262,784.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2	0.0
610001	Төсвийн байгууллага	2	2	0.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24	22	2.0
620001	Удирдах ажилтан	8	8	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	8	7	1.0
620003	Үйлчлэх ажилтан	6	5	1.0
620004	Гэрээт ажилтан	2	2	0.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	22	2.0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	8	1.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7	1.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	7	7	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	138,027.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	138,027.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	138,024.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	98.5
210301	Гэрэл, цахилгаан	98.5
210302	Түлш, халаалт	0.0
210303	Цэвэр, бохир ус	0.0
210304	Байрны түрээс	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	5,084.6
210401	Бичиг хэрэг	0.0
210402	Тээвэр, шатахуун	5,084.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,783.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0
210602	Тавилга	10,250.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.0
210604	Урсгал засвар	29,533.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	960.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,097.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	92,097.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3.2
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3.2
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	3.2
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	138,027.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	138,027.3
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	26,733.3
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	111,294.0
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**3.1. Тус сумын харьяа орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:**

Дархан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 1 төрийн сангийн, 3 тусгай сан, Дархан тохижилт ОНӨҮГ-ын нийт 7 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс ЗДТГ, Дархан тохижилт ОНӨҮГ-т аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус гаргасан. ИТХ, Хоршоо хөгжүүлэх сан, Орон нутгийн хөгжлийн сан аудитын түүвэрт хамрагдсан болно.

Харьяа орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 404,706.8 мянган төгрөгийн 12 алдаа зөрчил

илэрснээс 242,088.8 мянган төгрөгийн 6 алдаа¹г санхүүгийн тайланд аудитын явцад залруулсан. Үүнд:

1. ОНХС-ийн санхүүгийн тайланд зураг төсвийн үнийг урьдчилж гарсан зардлаар бүртгээгүй 20,000.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг залруулав.
2. Дархан тохижилт ОНӨҮГ-ын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийг буруу бүртгэсэн 222,088.8 мянган төгрөгийн 5 алдаа илэрснийг залруулсан.

Аудитаар илэрсэн 162,617.9 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 725.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 86,977.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлж, 74,915.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө. Үүнд:

1. ЗДТГ нэмэлт санхүүжилтийн данснаас томилолтоор ажилласан хүний буудал хоолны үнэд 725.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

2. ЗДТГ нэмэлт дансанд Бор-Өндөр УБҮ-ээс гэрээний дагуу 77,900.0 мянган төгрөгийг төвлөрүүлж зориулалт бусаар зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

3. ЗДТГ өмнөх оны зураг төсвийн 5,400.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

4. ОНХС-аас малчдад зориулсан сургалт сурталчилгааны зардлаас зориулалт бусаар 3677.8 мянган төгрөгийн барагшун худалдан авч малчдад тарааж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

5. ЗДТГ Засаг даргын нөөц сангаас 3,333.5 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулах захирамжид Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

6. Дархан тохижилт ОНӨҮГ 71,581.6 мянган төгрөгийн гүйлгээний нягтлан бодох бүртгэлийг давхар бичилт хөтлөөгүй, авлага өглөгийн дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

3.2. Тус сумын харьяа улсын төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Дархан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа улсын төсөвт 4 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс Стандарт дүгнэлт аудит ХХК Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, ЕБС-ийн санхүүгийн тайлангийн аудитыг гэрээгээр гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт тус тус өгсөн. Соёлын төвд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж түүвэрт хамруулсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 36,808.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илрүүлснээс 33,680.0

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 607.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,521.0 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Соёлын төв аж ахуйн материалд 33,680.0 мянган төгрөгийн уран сайхны гутал, хувцсыг орлого авахдаа дансыг буруу ангилж бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

2. Эрүүл мэндийн төв сахилгын шийтгэлтэй ажилтанд 607.6 мянган үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Эрүүл мэндийн төв эдийн засгийн ангилал зөрүүлэн урсгал зардлаас 2,521.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл худалдаж авсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгсөн.

3.3 Сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулагдаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ОНХС УГЗ -ыг бүртгээгүй	1	20,000.0			1	20,000.0	1	20,000.0				
Дархан тохижилт НББ-ийг буруу бүртгэсэн	5	222,088.8			5	222,088.8	5	222,088.8				
Соёлын төв материалыг буруу ангилсан	1	33,680.0			1	33,680.0	1	33,680.0				
Дүн	7	275,768.8	-	-	7	275,768.8	7	275,768.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ буудал, хоолны үнэ төлсөн	1	725.0	1	725.0								
ЗДТГ нэмэлт дансанд орлого авсан	1	77,900.0			1	77,900.0						

ЗДТГ авлагын үлдэгдэл барагдуулаагүй	1	5,400.0			1	5,400.0						
ОНХС үр ашиггүй зардал гаргасан	1	3,677.8			1	3,677.8						
ЗДТГ ЗД-ын нөөц сан хурлын тэмдэглэлгүй	1	3,333.5					1	3,333.5				
Дархан тохижилт НББ-ийг стандартаар хөтлөөгүй	1	71,581.6					1	71,581.6				
ЭМТ үр дүн олгосон	1	607.6	1	607.6								
ЭМТ зардлын ангилал зөрүүлсэн	1	2,521.0					1	2,521.0				
Дүн	8	94,164.9	2	1,332.6	3	86,977.8	3	5,854.5	0	0	0	0